



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ХҮРЭЭМАРАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 03 өдөр

Дугаар А119

Дэлгэрмөрөн

Бог малын хээлтүүлэгчид үзлэг ангилалт
хийх, баталгаажуулах тухай

Монгол улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Малын генетик нөөцийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.6.4, 16 дугаар зүйлийн 16.8.6 дахь заалиуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бог малын хээлтүүлэгчид үзлэг ангилалт хийх, баталгаажуулах ажлыг 05 дугаар сарын 03-ний өдрөөс 11 дүгээр сарын 10-ний өдрийн хооронд зохион байгуулсугай.

2. Бог малын хээлтүүлэгчийн малын стандартын шаардлага хангасан үржлийн малыг технологийн ажил үйлчилгээний нэгжид ялган төвлөрүүлж, мэргэжлийн байгууллагын мэдэлд шилжүүлэн ашиглуулах хуулийн заалтыг хэрэгжүүлж, хээлтэгч хээлтүүлэгчийн зохистой харьцааг баримтлан тухайн бүс нутагт ашиглахаар зөвшөөрөгдсөн хээлтүүлэгчээр дутагдаж буй хээлтүүлэгчийг нөхөн тавих, өсвөр хээлтүүлэгч шилж сонгох, малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн сан, малын удам зүйн үнэлгээний программын хэрэгжилтийг ханган, холбогдох тайланг Хүнс хөдөө аж ахуйн газарт хагас, бүтэн жилээр тайлагнахыг Мал аж ахуйн үйлдвэрлэлийн төлөвлөлт, менежмент, малын үржил бүртгэлийн асуудал хариуцсан мэргэжилтэн (Ч.Хүчитбаатар)-д үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Д.Баярсайхан)-д даалгасугай.

ДАРГА



С.СУМЪЯАБАЗАР

D /bichig hereg/ Zahiramj -2022 on

642201057